



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/496

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”, “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ын 6, 41 дэх хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2004 оны “Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч шагнал бий болгох тухай” 199 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Боловсрол, шинжлэх ухааны салбарын албан хаагчид шагнал олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнтэй ажиллахыг Боловсролын ерөнхий газар, аймаг, нийслэлийн боловсрол, шинжлэх ухааны газар, шинжлэх ухааны байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, журам зөрчсөн холбогдох албан тушаалтанд хариуцлагыг тооцох санал боловсруулан шийдвэрлүүлж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Г.Энхжаргал/-т даалгасугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны “Журам, маягт, загвар шинэчлэн батлах тухай” А/23 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэ журмыг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД




Л.ЭНХ-АМГАЛАН

142211820

Боловсрол, шинжлэх ухааны  
сайдын 2022 оны 11 дүгээр сарын  
25-ы өдрийн 1496 тоот тушаалын хавсралт

## БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН АЛБАН ХААГЧИД ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ



### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Боловсрол, шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан, онцгой амжилт гаргасан салбарын албан хаагч, Монгол Улсын болон гадаадын иргэнийг Засгийн газрын /цаашид “салбарын шагнал” гэх/ болон Боловсрол, шинжлэх ухааны яамны шагнал /цаашид “яамны шагнал” гэх/-д нэр дэвшүүлэх, тодорхойлох, шагнал олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

### Хоёр. Шагналын төрөл

- 2.1.Засгийн газрын шагнал нь дор дурдсан төрөлтэй байна. Үүнд:
- 2.1.1.“Боловсролын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг;
  - 2.1.2.“Шинжлэх ухааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг;
- 2.2.Боловсрол, шинжлэх ухааны яамны шагнал нь дор дурдсан төрөлтэй байна. Үүнд:
- 2.2.1.Яамны “Хүндэт дэвтэр”-т бичих;
  - 2.2.2.Яамны “Жуух бичиг”;
  - 2.2.3.“Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч” тэмдэг, үнэмлэх.

### Гурав. Шагнал олгох болзол

3.1.Боловсрол, шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулан, ажлын амжилт, бүтээл нь өмнөх түвшнээс ахиж, хамт олон, мэргэжлийн байгууллагаар үнэлэгдсэн салбарын албан хаагч, Монгол Улсын болон гадаадын иргэнд шагналыг яам, Засгийн газрын гэсэн дарааллаар олгоно.

3.2.Яамны шагналыг боловсрол, шинжлэх ухааны салбарт хамт олноо манлайлан 9-өөс доошгүй жил ажилласан салбарын албан хаагчид, Засгийн газрын шагналыг салбарт 13-аас доошгүй жил ажилласан, мэргэшлийн өндөр ур чадвартай багш, албан хаагч, удирдах ажилтанд /Боловсролын үйлчилгээний ажилтан хамаарахгүй/ тус тус олгоно.

3.3.Шагналыг Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 2.5-д зааснаас гадна тухайн салбар байгууллагын 50 болон түүнээс дээш 10 жилийн

давтамжтай тэгш ой, салбарын дор дурдсан тэмдэглэлт өдрийг тохиолдуулан тус тус олгоно. Үүнд:

3.3.1."Боловсролын тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр Дэлхийн /Монголын/ багш нарын өдөр; (жил бүрийн 10 дугаар сарын 05-ны өдөр)

3.3.2."Шинжлэх ухааны тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр Шинжлэх ухааны ажилтны өдөр (жил бүрийн 11 дүгээр сарын 4 дүгээр долоо хоногийн Ням гараг);

3.3.3."Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч" тэмдгээр Үндэсний бичиг үсгийн баяр (жил бүрийн 5 дугаар сарын эхний Ням гараг);

3.4.Боловсрол, шинжлэх ухааны сайд орон нутагт албан томилолтоор ажиллах хугацаанд энэ журмын 3.3-т зааснаас гадна салбарын шагналыг олгож болно.

3.5.Монгол Улсын Засгийн газрын шагналаар шагнахад дараах шаардлагыг хангасан байдлыг харгалзан үзнэ.

3.5.1."Боловсролын тэргүүний ажилтан" (БТА) хүндэт тэмдэг:

а.Ажил мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн түвшин нь сүүлийн жилүүдэд тогтвортой өссөн үзүүлэлттэй, багш, ажилтны дунд зохиогддог Улсын чанартай уралдаан, тэмцээнд эхний 3 байрт орсон багш;

б.Тэргүүн туршлагаа аймаг, нийслэлийн хэмжээнд амжилттай түгээн дэлгэрүүлсэн нь холбогдох дээд шатны байгууллага /Боловсролын Ерөнхий газар, Нийслэлийн боловсролын газар, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар/-ын тодорхойлолтоор баталгаажсан багш, боловсролын салбарын төрийн захиргааны албан хаагч, удирдах ажилтан;

в.Тухайн шагналын дагалдах мөнгөн дүн 300 000 / Гурван зуун мянга/ төгрөг байна.

3.5.2."Шинжлэх ухааны тэргүүний ажилтан (ШУТА) хүндэт тэмдгээр:

а.Эрдэм шинжилгээний бүтээл нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж, олны хүртээл болсон зэргээр шинжлэх ухааны хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан эрдэмтэн, судлаач;

б.Шинжлэх ухааны салбарын мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэхэд зохих хувь нэмэр оруулсан, 3 болон түүнээс дээш судлаачийн эрдмийн ажлыг удирдаж, докторын зэрэг хамгаалуулсан их, дээд сургуулийн эрдэмтэн багш, судлаач;

в.Шинэ бүтээл, оновчтой санаачилга гарган улс эх орны өмнө тулгамдсан асуудлыг шинжлэх ухаан, технологийн ололтод түшиглэн шийдсэн инженер, зохион бүтээгч, эрдэмтэн судлаач;

г.Монгол Улсын шинжлэх ухааны салбарын хөгжил, салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан гадаадын иргэн;

д.Тухайн шагналын дагалдах мөнгөн дүн 300 000 / Гурван зуун мянга/ төгрөг байна.

### 3.5.3. “Хүндэт дэвтэр”-т бичигдэх:

Сайдын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн боловсрол, шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан тухайн салбар, яамны хувьд хамгийн хүндтэй эрхэм хүн;

### 3.5.4. “Жуух бичиг”ээр:

а.Ажил мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн түвшин нь сүүлийн жилүүдэд тогтвортой өссөн үзүүлэлттэй, багш, ажилтны дунд зохиогддог Улсын чанартай уралдаан, тэмцээнд эхний 3 байрт шалгарсан багш;

б.Тэргүүн туршлагаа аймаг, нийслэлийн хэмжээнд амжилттай түгээн дэлгэрүүлсэн нь холбогдох дээд шатны байгууллага /Боловсролын Ерөнхий газар, Нийслэлийн боловсролын газар, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар/, харьяалагдах байгууллагын тодорхойлолтоор баталгаажсан багш, боловсролын салбарын төрийн албан хаагч;

в.Тухайн шагналын дагалдах мөнгөн дүн 200,000 / Хоёр зуун мянга/ төгрөг байна.

### 3.5.5. “Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч” (ҮБСД) тэмдгээр:

а.Бичиг үсгийн үнэт дурсгал, монгол бичгийг дээдлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах үйлсэд амжилт гаргаж, үндэсний бичгээр улсын хэмжээнд зохион байгуулагдсан уралдаан тэмцээнд эхний байрт шалгарсан, онцгой бүтээл гаргасан багш, судлаач, бичиг соёлын зүтгэлтэн, иргэн.

в.Тухайн шагналын дагалдах мөнгөн дүн 250,000 / Хоёр зуун тавин мянга/ төгрөг байна.

3.6.Энэ журмын 3.5-т заасан салбарын шагнал /Боловсролын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг, Шинжлэх ухааны ажилтан хүндэт тэмдэг, Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч, Жуух бичиг/-д дагалдах мөнгөн шагналыг шагналд нэр дэвшүүлсэн тухайн байгууллагаас олгоно.

## **Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох**

4.1.Салбарын шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлэгч анхан шатны /нэр дэвшигчийн ажиллаж байгаа байгууллага, ахмад настан бол үндсэн байгууллага,

төрийн бус гэх мэт/ байгууллага дор дурдсан баримт бичгийг баяр, тэмдэглэлт өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө журмын 4.2-т заасан байгууллагад цахимаар гаргана. Шагналд нэр дэвшүүлэхдээ өмнө шагнагдсан хугацаанаас 5-аас доошгүй жил тухайн салбартаа тогтвортой ажилласан, ажлын амжилт бүтээл нь өмнөх түвшнээс өссөн зэргийг харгалзана. Шагналд нэр дэвшүүлэхэд дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ.

4.1.1.Шагнуулах тухай хүсэлт гаргасан байгууллагын албан бичиг;

4.1.2.Хамт олны хурлын тэмдэглэл;

4.1.3.Ажил байдлын дэлгэрэнгүй тодорхойлолт, бүтээлийн жагсаалт;

4.1.4.Батлагдсан загварын дагуу танилцуулга /цээж зураг, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан/ анкет;

4.1.5.Яамны болон бусад шагналаар шагнагдсан бол тэдгээрийг гэрчлэх үнэмлэхийн хуулбар;

4.1.6."Шинжлэх ухааны тэргүүний ажилтан" шагналд нэр дэвшигч нь бүтээлийн жагсаалт болон патент, ашигтай загварын гэрчилгээ, докторын зэрэг хамгаалуулсныг нотлох баримт;

4.1.7. Энэ журмын 3.5-т заасан дагалдах мөнгийг олгох тухай байгууллагын албан тоот;

4.2.Шагналд нэр дэвшүүлэгч анхан шатны байгууллага нь шагналд нэр дэвшигчийн мэдээллийг дор дурдсан холбогдох дээд байгууллагад уламжилна.

4.2.1.Яамны "Хүндэт дэвтэр", "Жуух бичиг", "Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч" тэмдэг, "Боловсролын тэргүүний ажилтан" шагналаар тодорхойлсон анхан шатны байгууллага нь нэр дэвшигчийн баримт бичгийг харьяа нутаг дэвсгэрийн Боловсрол, шинжлэх ухааны газарт;

4.2.2.Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, политехник коллеж нь нэр дэвшигчийн баримт бичгийг харьяа нутаг дэвсгэрийн Боловсрол, шинжлэх ухааны газарт;

4.2.3.Харьяа нутаг дэвсгэрийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь Боловсролын ерөнхий газарт;

4.2.4.Их, дээд сургууль, нь Монголын их, дээд сургуулиудын консорциум/-т;

4.2.5."Шинжлэх ухааны тэргүүний ажилтан" шагналаар шагнуулахаар тодорхойлсон анхан шатны байгууллага нь нэр дэвшигчийн баримт бичгийг яамны шинжлэх ухааны бодлогын асуудал хариуцсан нэгжид.

4.3.Журмын 4.2.3, 4.2.4-т заасан байгууллага нь мөн журмын 4.1-д заасан баримт бичгийг архивын түр хадгалах нэгж үүсгэн, шагналд нэр дэвшигчийн мэдээллийг баяр, тэмдэглэлт өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө боловсролын салбарын мэдээллийн систем ([www.esis.edu.mn](http://www.esis.edu.mn))-д цахим хэлбэрээр мэдүүлэх, шагналын системийн цонхны дээд хэсэгт байрлах Эксел файл /дүрс/-ыг сонгох

замаар нэр дэвшигчийн овог, нэр, регистрийн дугаар, тодорхойлсон шагналын жагсаалтыг цахим болон цаасан хэлбэрээр Боловсролын ерөнхий газарт, Боловсролын ерөнхий газар болон яамны Шинжлэх ухаан, технологийн бодлогын асуудал хариуцсан нэгж нь яаманд хандсан албан бичигт хавсарган ирүүлнэ.

4.4.Журмын 4.1-т заасан баримт бичгийг хугацаа хожимдуулсан, нэр дэвшигчийн бичиг баримтын бүрдэл дутуу, эсхүл хуурамчаар бүрдүүлсэн, шагналд нэр дэвших болзлыг хангаагүй албан хаагчийн нэрийг дэвшүүлсэн тохиолдолд шагнал олгох асуудлыг хэлэлцэхгүй бөгөөд ([www.esis.edu.mn](http://www.esis.edu.mn))-д татгалзсан төлөвт орсон байна.

4.5.Шагналд нэр дэвшүүлэх болзол, шаардлагыг бүрэн хангасан албан хаагчийн холбогдох мэдээллийг цахимаар яамны шагналын асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.

### **Тав. Шагнал шийдвэрлэх, олгох**

5.1.Шагналд нэр дэвшигчийн материалыг яамны шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн цахимаар хүлээн авч журамд заасны дагуу материалыг хянан, саналаа удирдлагад танилцуулна.

5.2.Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал гаргаж, шагнах асуудлыг шийдвэрлэх бөгөөд шагнасан тухай шийдвэр, шагналын хамт боловсролын салбарын шагналыг Боловсролын ерөнхий газарт, шинжлэх ухааны салбарын шагналыг яамны Шинжлэх ухаан, технологийн бодлогын асуудал хариуцсан нэгжид хүлээлгэж өгнө.

5.3.Шагналын тэмдэг, үнэмлэхийг үрэгдүүлсний улмаас нөхөн авах тохиолдолд дор дурдсан баримт бичгийг бүрдүүлэн яаманд ирүүлнэ.

5.3.1.Нөхөн олгохыг хүссэн өргөдөл;

5.3.2.Иргэний үнэмлэхийн хуулбар;

5.3.3.Шагналын үнэмлэхийн хуулбар /Хэрэв үнэмлэх, жуух нь үрэгдсэн бол шагнасан тухай шийдвэрийг шагнал олгогдсон хугацаанаас хамааран Архивын ерөнхий газар болон Боловсрол, шинжлэх ухааны яамны архиваас хуулбарыг авна/

5.4.Энэ журмын 5.3-д заасан баримтыг үндэслэн нөхөн олгоход гарсан зардлыг хүсэлт гаргасан тал хариуцна. Онцгойлон хүндэтгэх /гал, усны аюул, төлбөрийн чадвар, Монгол Улсын гавьяат болон түүнээс дээш цолтой гэх мэт/ шалтгааны улмаас үнэ төлбөргүй олгож болно.

5.5.Энэ журмын 5.3-д заасан баримтыг үндэслэн шагналыг нөхөн олгоход гарсан зардлыг тухайн иргэнээс гаргуулна.

## **Зургаа. Шагналын мэдээллийн сан**

6.1.Салбарын шагналын цахим мэдээллийн системтэй байна.

6.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Монголын их, дээд сургуулийн консорциумын шагналын асуудал хариуцсан ажилтанд цахим бүртгэлийн эрхийг Боловсролын ерөнхий газрын шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн олгоно.

6.3.Мэдээллийн системийн еангийн бүрдүүлэлт, баяжилт хөдөлгөөнийг аймаг, нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Монголын их, дээд сургуулийн консорциумын шагналын асуудал хариуцсан ажилтан хийх бөгөөд Боловсролын ерөнхий газрын шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хариуцан хөтөлж, хяналт тавина.

6.4.Шагналын цахим мэдээллийн систем нь тухайн баяр, ой, тэмдэглэлт өдөр болох өдрөөс 90 хоногийн өмнө нээгдэж, 30 хоногийн өмнө хаагдах ба энэ хугацаанд хүсэлт гаргагч байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан нь цахим мэдээллийн системд хандаж шагналд нэр дэвшигчийн мэдээллийг бүрэн оруулсан байна.

6.5.Шагналд нэр дэвшигчийн холбогдох мэдээллийг цахим бүртгэлийн системд хуурамчаар бүртгүүлсэн нь нотлогдсон тохиолдолд тухайн байгууллагын эрхийг 1 жил хүртэлх хугацаанд хаана.

6.6.Аймаг, нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь шагналын бүртгэл мэдээллийн системд эрхтэй байх ба шинээр шагнагдсан ажилтны болон шагнагдах болзол, шаардлагыг хангасан иргэнийг эрэмбэлэн гаргасан шагналын судалгааг батлагдсан маягтын дагуу шинэчилж, жил бүрийн 6, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Боловсролын ерөнхий газарт, Боловсролын ерөнхий газар нь жил бүрийн 6, 12 дугаар сарын 20-ны дотор Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн захиргааны удирдлагын нэгжид цахим хэлбэрээр ирүүлнэ.

### **Долоо. Бусад зүйл**

7.1.Нам, улс төрийн болон сонгуулийн үеэр салбарын шагналыг цахим системд оруулаагүй, тухайн байгууллагын удирдлагын тодорхойлолтгүйгээр олгохгүй.

7.2.Салбарын шагналын журмын шаардлага хангаагүй болон цахим мэдээллийн системд мэдээлэл ирүүлээгүйгээр шагнагдсан зөрчилтэй шагналыг хураан авч хүчингүй болгож, хуульд заасны дагуу шийдвэрлүүлнэ.

7.3.Салбарын шагналтай холбоотой санал, гомдлыг зөвхөн мэдээллийн системээр дамжуулан хүлээн авч, дахин хянаж, шийдвэрлэнэ. Бусад тохиолдолд зөрчил хэмээн үзэж тухайн байгууллагад сануулга өгөх, журмын 6.5-д заасны дагуу эрхийг түдгэлзүүлнэ.

7.4.Боловсрол, шинжлэх ухааны яамны албан хаагчид болон харьяа агентлаг, байгууллагын зүгээс Төрийн дээд одон медаль, Хүндэт өргөмжлөлөөр шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолтыг судлан, удирдлагад танилцуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”-д заасны дагуу нэр дэвшүүлэн, өргөн мэдүүлнэ. Мөн журмын 9-д заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг даргад санал хүргүүлж болно.

---oOo---